



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2024/250/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2024 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитор: Ц.Уртнасан Утас: 70376994 Цахим хаяг: urtaa6969@gmail.com
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-11
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	11-16
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	11-12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	12-13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	13-14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14-16
4. Аудитын тайлан	16
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17-18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. Аудитын илрүүлэлт	18-19
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	19-20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
НДШ	Нийгмийн даатгалын шитгэл
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТБОНӨХБАУХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

АЛТАНБУЛАГ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Б.ЭРДЭНЭ-ОЧИР ТАНАА

2024.02.28 № СЭА-2024/250/НА-СТА-ТШЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Алтанбулаг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд тус сургууль нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 18,018.2 мянган төгрөгийн хими, физикийн кабинетийн тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүн, сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 65,122.4 мянган төгрөгийн биеийн тамирын талбайн тохижилтын ажил хийгдсэнийг капиталжуулж, бүртгэсэн байна.

Аудитын гол асуудал

Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 18 зорилтын хүрээнд 57 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 91.3 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭНХТУЯА



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	295,455,380.52	338,870,699.94
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	131,506,747.29	142,170,462.40
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	131,506,747.29	142,170,462.40
31210	Төгрөг	131,506,747.29	142,170,462.40
31211	Төрийн сангийн харилцах	131,506,747.29	142,170,462.40
33	АВЛАГА	205,893.92	152,411.01
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	205,893.92	152,411.01
35	БАРАА МАТЕРИАЛ	163,742,739.31	196,547,826.53
35400	Хангамжийн материал	163,742,739.31	196,547,826.53
35410	Бичиг хэргийн материал	633,000.00	1,348,000.00
35420	Аж ахуйн материал	94,604,450.72	102,853,678.72
35450	Барилгын засварын материал	220,000.00	1,590,400.00
35460	Хүнсний материал	3,735,000.00	5,710,180.00
35470	Бусад хангамжийн материал	64,550,288.59	85,045,567.81
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,061,204,201.08	2,069,967,809.07
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,061,204,201.08	2,069,967,809.07
39200	Биет хөрөнгө	1,813,358,201.08	1,823,507,809.07
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,695,817,070.84	1,695,817,070.84
39202	Хуримтлагдсан элэгдэл	(186,900,627.18)	(235,040,466.30)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	21,063,500.00	21,063,500.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(19,438,250.00)	(20,738,450.00)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	345,742,040.47	354,823,760.47
39206	Хуримтлагдсан элэгдэл	(149,439,877.11)	(198,591,160.64)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	93,968,016.06	133,185,916.06
39208	Хуримтлагдсан элэгдэл	(40,281,070.79)	(52,543,179.28)
39209	Зам, гүүрийн байгууламж	7,952,316.32	78,240,355.32
39210	Хуримтлагдсан элэгдэл	(2,350,024.54)	(3,221,354.41)
39214	Бусад үндсэн хөрөнгө	53,579,495.97	53,579,495.97
39215	Хуримтлагдсан элэгдэл	(14,512,064.17)	(14,512,064.17)
39217	Ном	8,157,675.21	11,444,385.21
39300	Биет бус хөрөнгө	247,846,000.00	246,460,000.00
39301	Програм хангамж	7,810,000.00	7,810,000.00

39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,266,000.00)	(3,652,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	242,302,000.00	242,302,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,356,659,581.60	2,408,838,509.01
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	6,847,348.82
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	6,847,348.82
41300	Өглөг	0.00	6,847,348.82
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.00	6,847,348.82
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,356,659,581.60	2,401,991,160.19
51	Засгийн газрын хувь оролцоо	2,356,659,581.60	2,401,991,160.19
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,487,967,337.20	1,487,967,337.20
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	1,487,967,337.20	1,487,967,337.20
51200	Хуримтлагдсан үр дүн	(541,556,929.46)	(496,225,350.87)
51210	Өмнөх үеийн үр дүн	(2,898,666,511.06)	(541,556,929.46)
51220	Тайлант үеийн үр дүн	2,357,109,581.60	45,331,578.59
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,410,249,173.86	1,410,249,173.86
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,356,659,581.60	2,408,838,509.01

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,049,835,460.38	2,163,507,818.62
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,268,241,560.38	102,032,218.62
120	Нийтлэг татварын бус орлого	2,268,241,560.38	102,032,218.62
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	14,748,600.00	8,891,251.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	5,710,903.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	14,748,600.00	3,180,348.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	2,092,742,613.78	73,825,569.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	160,750,346.60	19,315,398.62
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,781,593,900.00	2,061,475,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,563,218,300.00	1,832,914,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,563,218,300.00	1,832,914,100.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	218,375,600.00	228,561,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	218,375,600.00	228,561,500.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,692,725,878.78	2,118,176,240.03

21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,692,725,878.78	2,118,176,240.03
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,605,011,763.78	2,003,108,270.03
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,096,549,076.90	1,354,576,466.67
210101	Үндсэн цалин	773,834,506.64	838,355,527.46
210102	Нэмэгдэл	258,181,820.26	333,324,049.21
210104	Урамшуулал	64,532,750.00	182,896,890.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	135,839,366.89	166,427,947.73
210201	Тэтгэврийн даатгал	92,866,803.10	110,137,947.73
210202	Тэтгэмжийн даатгал	10,958,965.55	14,072,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,767,172.35	11,257,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,103,979.07	2,814,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	21,142,446.82	28,145,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	140,870,400.00	227,466,248.82
210301	Гэрэл, цахилгаан	15,478,438.00	16,280,363.28
210302	Түлш, халаалт	105,767,627.00	189,330,861.54
210303	Цэвэр, бохир ус	19,624,335.00	21,855,024.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,100,007.69	1,300,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,546,100.00	1,300,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,912,250.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,797,550.00	0.00
210408	Бараа материал акталсны зардал	6,844,107.69	0.00
2105	Нормативт зардал	64,026,660.00	61,167,650.00
210502	Хоол, хүнс	64,026,660.00	61,167,650.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,002,100.00	14,588,670.00
210604	Урсгал засвар	19,002,100.00	14,588,670.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,123,600.00	12,951,056.40
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,748,600.00	5,710,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,375,000.00	7,240,256.40
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	123,500,552.30	164,630,230.41
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	25,056,300.00	32,526,660.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,842,439.60	18,992,809.40
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	90,601,812.70	113,110,761.01
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	87,714,115.00	115,067,970.00

2132	Бусад урсгал шилжүүлэг	87,714,115.00	115,067,970.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	87,714,115.00	86,235,970.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	28,832,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	2,357,109,581.60	45,331,578.59
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	2,357,109,581.60	45,331,578.59

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,796,342,500.00	2,070,366,851.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	14,748,600.00	8,891,251.00
120	Нийтлэг татварын бус орлого	14,748,600.00	8,891,251.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	14,748,600.00	8,891,251.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	5,710,903.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	14,748,600.00	3,180,348.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,781,593,900.00	2,061,475,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,563,218,300.00	1,832,914,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,563,218,300.00	1,832,914,100.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	218,375,600.00	228,561,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	218,375,600.00	228,561,500.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,605,772,352.71	2,011,654,335.89
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,605,772,352.71	2,011,654,335.89
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,514,316,337.71	1,894,810,035.89
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,097,941,252.90	1,354,576,291.74
210101	Үндсэн цалин	745,902,911.90	900,832,449.12
210102	Нэмэгдэл	287,491,390.26	370,423,224.78
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	0.00
210104	Урамшуулал	64,546,950.74	83,320,617.84
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	134,653,084.81	166,374,639.75
210201	Тэтгэврийн даатгал	89,908,148.74	110,084,639.75
210202	Тэтгэмжийн даатгал	10,742,922.94	14,072,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,770,607.10	11,257,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,100,789.07	2,814,400.00

210205	Эрүүл мэндийн даатгал	23,130,616.96	28,145,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	140,870,400.00	220,618,900.00
210301	Гэрэл, цахилгаан	15,478,438.00	13,031,254.16
210302	Түлш, халаалт	105,767,627.00	187,256,300.00
210303	Цэвэр, бохир ус	19,624,335.00	20,331,345.84
2105	Нормативт зардал	59,114,700.00	61,366,500.00
210502	Хоол, хүнс	59,114,700.00	61,366,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,378,100.00	7,942,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	200,000.00	0.00
210604	Урсгал засвар	19,178,100.00	7,942,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,073,600.00	16,799,756.40
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,748,600.00	5,710,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	9,325,000.00	11,088,956.40
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	48,285,200.00	67,131,348.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	32,306,500.00	50,346,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	15,978,700.00	16,784,448.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	91,456,015.00	116,844,300.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	91,456,015.00	116,844,300.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	91,456,015.00	88,012,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	28,832,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	190,570,147.29	58,712,515.11
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	59,063,400.00	48,048,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	59,063,400.00	48,048,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	59,063,400.00	48,048,800.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	59,063,400.00	48,048,800.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(59,063,400.00)	(48,048,800.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	131,506,747.29	10,663,715.11
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	131,506,747.29
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	131,506,747.29	142,170,462.40

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	1,487,967,337.20	1,410,249,173.86	(2,898,666,511.06)	(450,000.00)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,487,967,337.20	1,410,249,173.86	(2,898,666,511.06)	(450,000.00)
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	2,357,109,581.60	2,357,109,581.60
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,487,967,337.20	1,410,249,173.86	(541,556,929.46)	2,356,659,581.60
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,487,967,337.20	1,410,249,173.86	(541,556,929.46)	2,356,659,581.60
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,487,967,337.20	1,410,249,173.86	(541,556,929.46)	2,356,659,581.60
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	45,331,578.59	45,331,578.59
20	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,487,967,337.20	1,410,249,173.86	(496,225,350.87)	2,401,991,160.19

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,201,873,548.00	2,059,703,135.89	142,170,412.11	92.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,973,312,048.00	1,831,141,635.89	146,170,464.11	92.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,973,312,048.00	1,714,297,335.89	136,485,664.11	92.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,467,657,700.00	1,354,576,291.74	113,081,408.26	92.3
210101	Үндсэн цалин	990,887,000.00	900,832,449.12	90,054,550.88	90.9
210102	Нэмэгдэл	396,442,500.00	370,423,224.78	26,019,275.22	93.4
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	-	-	-

210104	Урамшуулал	80,328,200.00	83,320,617.84	-2,992,417.84	103.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	183,457,100.00	166,374,639.75	17,082,460.25	90.7
210201	Тэтгэврийн даатгал	124,750,900.00	110,084,639.75	14,666,260.25	88.2
210202	Тэтгэмжийн даатгал	14,676,600.00	14,072,500.00	604,100.00	95.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,741,200.00	11,257,800.00	483,400.00	95.9
210204	Ажилгүйдлийн даатгал	2,935,300.00	2,814,400.00	120,900.00	95.9
210205	Эрүүл мэндийн даатгал	29,353,100.00	28,145,300.00	1,207,800.00	95.9
	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	220,618,900.00	220,618,900.00		100.0
210301	Гэрэл, цахилгаан	13,031,254.16	13,031,254.16		100.0
210302	Түлш, халаалт	187,256,300.00	187,256,300.00		100.0
210303	Цэвэр, бохир ус	20,331,345.84	20,331,345.84		100.0
	Эд хогшил, урсгал засварын зардал	7,942,600.00	7,942,600.00		100.0
210604	Урсгал зардал	7,942,600.00	7,942,600.00		100.0
2105	Нормативт зардал	61,366,500.00	61,366,500.00	-	100.0
210502	Хоол, хүнс	61,366,500.00	61,366,500.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,800,100.00	16,799,756.40	343.6	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,710,900.00	5,710,800.00	100	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	11,089,200.00	11,088,956.40	243.6	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	117,501,548.00	115,180,148.00	2,321,400.00	94.8
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	100,717,048.00	98,395,700.00	2,321,348.00	94.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	16,784,500.00	16,784,448.00	52	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	126,529,100.00	116,844,300.00	9,684,800.00	92.4
2132	Бусад урсгал шилжүүлэг	126,529,100.00	116,844,300.00	9,684,800.00	92.4
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	97,697,100.00	88,012,300.00	9,684,800.00	90.1
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	28,832,000.00	28,832,000.00	-	100.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,201,873,548.00	2,070,366,851.00	131,506,697.00	93.2
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,832,914,100.00	1,832,914,100.00	-	100.0
310001	Улсын төсвөөс санхүүжих	1,832,914,100.00	1,832,914,100.00	-	100.0
	Орон нутгийн төсвөөс	228,561,500.00	228,561,500.00		
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	140,397,948.00	8,891,251.00	131,506,697.00	6.2

350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,710,900.00	5,710,900.00		100.0
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,180,348.00	3,180,348.00		44.3
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	131,506,700.00	0	0	0.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	131,506,747.29	0	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	142,170,462.40	0	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Алтанбулаг сумын ерөнхий боловсролын сургууль нь “Сурагчдын хичээл сурлагын хоцрогдлыг арилгахад бүх талын хамтын ажиллагааг ханган ажиллах” гэсэн зорилт тавин ажиллаж байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Багш бүр сургалтын хөтөлбөр, төлөвлөлтийг боловсруулан сурагчдын сурлагын хоцрогдлыг арилгахад бүх талын хамтын ажиллагааг хангах
- Мэдээллийн хөгжлийн төвд суурилан видео, цахим хичээл болон цахим контентыг хичээлдээ ашиглаж хэвшин багш, суралцагчдыг шинжлэн судлах, мэдээлэл харилцааны технологид суралцуулна.
- Сургалтын арга хэлбэрийг оновчтой сонгон, заах арга зүйгээ хөгжүүлж хамтран ажиллах
- Сургуулийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэх сурч боловсрох ажиллах эрүүл, аюулгүй таатай орчныг эцэг эх, улс, аймаг, орон нутгийн бусад байгууллагуудтай хамтран ажиллах замаар бий болгоно.

3.2. Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Боловсролын ерөнхий хууль 2023 оны 07 дугаар сарын 07-нд батлагдсан,
- Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон,
- БШУС-ын 2023 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 1/2714 тоот албан бичгээр боловсролын байгууллагын төсвийн шинэчлэлийн хүрээнд “1.ЕБС-д

сургалтын тоног төхөөрөмжийн нөхөн хангалт шийдвэрлэх”, “2.Цэцэрлэгт шаардлагатай хүүхдийн тоглоом, наадгай, зөөлөн эдлэл ханган нийлүүлэх, худалдан авах ажиллагааг зохион байгуулах” чиглэлийг хүргүүлсэн гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд БШУЯ-ны Хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын Дотоод аудитын хэлтсээс хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Алтанбулаг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Тус байгууллага нь БШУС-ын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, шинжлэх ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

3.4. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Алтанбулаг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт

байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 53,762.6 мянган төгрөгөөр буюу 2.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

<i>/мянган төгрөгөөр/</i>			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	131,506.70	142,170.50	10,663.80
Авлага	205.9	152.4	(53.50)
Бараа материал	163,742.70	196,547.80	32,805.10
Үндсэн хөрөнгө	2,061,204.20	2,069,967.80	8,763.60
Нийт хөрөнгө	2,356,659.50	2,408,838.50	52,179.00
Өр төлбөр		6,847.30	6,847.30
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,356,659.50	2,401,991.20	45,331.70
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,356,659.50	2,408,838.50	52,179.00

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 142,170.5 мянган төгрөг болж 10,663.8 мянган төгрөгөөр өссөн нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.9¹-д заасны дагуу гүйцэтгэлд суурилсан санхүүжилтэд шилжсэнээр төсвийн хэмнэлтийг төвлөрүүлээгүйгээс,
- Авлага дансны үлдэгдэл 152.4 мянган төгрөг болж 53.5 мянган төгрөгөөр буурсан нь цалингаас суутгасан НДШ-ийг илүү төлснөөс,
- Бараа материал дансны үлдэгдэл 196,547.8 мянган төгрөг болж 32,805.1 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 209,368.5 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авсан, аймгийн БШУГ-аас 6,260.6 мянган төгрөгийн түрээсийн ном хичээлийн хэрэглэгдэхүүн, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 13,054.8 мянган төгрөгийн физик, технологийн сургалтын хэрэглэгдэхүүнийг үнэ төлбөргүй хүлээн авч, нийт 195,878.8 мянган төгрөгийн бараа материал зарцуулснаас,

¹ Энэ хуулийн 7.7 дахь хэсэг эрүүл мэнд, боловсролын салбарын гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн зарчмаар санхүүждэг байгууллагын төсвийн захирагчид хамаарахгүй

- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,069,967.8 мянган төгрөг болж, 8,763.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр 48,048.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авсан, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 4,963.4 мянган төгрөгийн физикийн сургалтын тоног төхөөрөмж, сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 65,122.4 мянган төгрөгийн биеийн тамирын талбайн тохижилтын ажил хийгдсэнийг капиталжуулсан, БШУЯ-ны хөрөнгө оруулалтаар 3,286.8 мянган төгрөгийн ном, эцэг эхийн хандиваар 453.0 мянган төгрөгийн ширээ үнэ төлбөргүй хүлээн авч, тайлант онд 8,763.6 мянган төгрөгийн элэгдлийг нэмж байгуулснаас,
- Өр төлбөр дансны үлдэгдэл 6,847.3 мянган төгрөгөөр өссөн нь гэрэл цахилгаан, цэвэр бохир усны өр төлбөр үүссэнээс тус тус шалтгаалсан байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус сургуулийн 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,410,675.7 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 191,880.5 мянган төгрөг зэрэг нийт зарлагыг 1,602,556.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслийн саналыг цалин НДШ-н зардлыг 114,426.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, тогтмол зардлыг 29,648.4 мянган төгрөгөөр бууруулж нийт төсвийг 1,572,907.8 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант онд төсвийн зохицуулалтаар үдийн цай, дотуур байрны хоолны зардлыг 45,838.0 мянган төгрөгөөр, цалин, НДШ-н зардлыг 261,974.1 мянган төгрөгөөр, зөв монгол хүүхэд үндэсний хөтөлбөрийн зардлыг 46,789.0 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 4,000.0 мянган төгрөгөөр, боловсролын байгууллагын багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх зардлыг 9,980.3 мянган төгрөгөөр, тогтмол зардлыг 66,429.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж нийт 2,070,366.8 мянган төгрөгийн эх үүсвэрийг баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр 13 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 1,964,421.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 228,561.5 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 3,180.3 мянган төгрөг, түрээсийн номын орлого 5,710.9 мянган төгрөг буюу нийт 2,201,873.7 мянган төгрөгийн эх үүсвэрийг урсгал үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөгдсөн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,059,703.1 мянган төгрөг буюу 94.0 хувьтай байгаа нь цалин, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 126,884.0 мянган төгрөгөөр, үдийн цай, дотуур байрны хоолны зардлыг 15,286.5 мянган төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

<i>/мянган төгрөгөөр/</i>							
Д/д	Хөтөлбөр	Д/д	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	71802 Ерөнхий боловсрол	1	80226- Байр ашиглалтын үйлчилгээ	4,435.70	4,435.70	-	100.0
		2	80312- Сургалт семинар	2,217.80	2,217.80	-	100.0
		3	81605- Эрүүл мэндийг дэмжих	5,405.80	3,084.40	(2,321.40)	57.0
		4	81801- Үдийн цай хөтөлбөр	97,697.10	88,012.30	(9,684.80)	90.0
		5	81806- Дотуур байрны үйлчилгээ	104,538.90	101,258.70	(3,280.20)	97.0
		6	81816- Зөв монгол хүүхэд	46,789.00	46,789.00	-	100.0
		7	81823- Боловсролын багшийн сургалт	9,980.30	9,980.30	-	100.0
		8	81827- Бичиг үсгийн боловсрол	3,220.00	3,220.00	-	100.0
		9	81834- Боловсролын стандарт сургалт	1,393,284.60	1,278,347.00	(114,937.60)	92.0
		10	81835- Сургалтын хэвийн үйл ажиллагаа	296,851.60	284,905.30	(11,946.30)	96.0
		11	81848-Сурах бичгийн түрээс	5,710.90	5,710.80	(0.10)	100.0
		12	80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	228,561.50	228,561.50	-	100.0
		13	83602-Засаг даргын нөөц хөрөнгөөс хуваарилсан	3,180.40	3,180.40	-	100.0
Нийт				2,201,873.60	2,059,703.20	(142,170.40)	94.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хааж, нэмэлт санхүүжилттэй холбоотой гүйлгээг урсгал дансаар дамжуулан гүйцэтгэж, тайланг төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэсэн байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд дараах худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАУХА тухай хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулж, зохион байгуулсан байна. Үүнд:

/ мянган төгрөгөөр /

№	Тухайн жилд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо, хэмжээ, хүчин чадал	Батлагдсан төсөв	Гэрээний дүн	Тендер шалгаруулалтын арга
1	Дотуур байрны хоол	50,015.6	51,986.9	НТШ
2	Үдийн цай	82,797.3	88,012.3	НТШ
	Нийт дүн	132,812.9	139,999.2	

Бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендер шалгаруулалт /Анхны батлагдсан төсвөөр тендерийн үнийн саналыг өгсөн./ -ыг 2 удаа зарлаж, гүйцэтгэгчээр шалгарсан “Бумбат арвижих” ХХК-тай 2023 оны 09 дүгээр сарын 23-ний өдөр гэрээ байгуулж, худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

Тайлант онд хоол хүнс, цэвэрлэгээний материалыг Бумбат арвижих ХХК, бичиг хэрэг, ахуйн бараа, нэг удаагийн хамгаалах хэрэгсэл, Цахим Ертөнц ХХК, урсгал засварын материалыг Сэлэнгэ титан ХХК-тай тус тус худалдан авах гэрээ байгуулан ажилласан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын ерөнхий боловсролын сургуулийн /цаашид Алтанбулаг сумын ерөнхий боловсролын сургууль гэх/ 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал,

дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу аудитор Ц.Уртнасан гүйцэтгэж, хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Алтанбулаг сумын ерөнхий боловсролын сургууль нь 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2024 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2. Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,692,725.8 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 16,927.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт:

Алтанбулаг сумын ерөнхий боловсролын сургууль нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Үйл ажиллагаатай холбоотой сурталчилгаа, баяр ёслолын арга хэмжээг зохион байгуулаагүй, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдаж аваагүй,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд тус сургууль нь шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 20 төрлийн 171 мэдээллээс 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, 7 мэдээллийг огт мэдээлээгүй байна.Үүнд:

- Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын гүйлгээний мэдээллийг 2 удаа хугацаа хоцроож мэдээлсэн,
- Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын гүйлгээний 7 удаагийн мэдээллийг огт мэдээлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн “Шилэн дансны тухай хуулийн дагуу холбогдох мэдээллийг тогтоосон хугацаанд бүрэн мэдээлж байх” гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс зөрчлийг тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана.”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд бусад хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй болно.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 123 дугаар албан бичгээр “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” захидлыг хүргүүлсэн бөгөөд тус сургуулийн 2022 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар нягтлан бодогчийн тооцооллын алдаанаас цалин илүү тооцож олгосон 1,345.6 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, төлбөрийн цахим баримтаар баталгаажуулалгүйгээр 11,859.2 мянган төгрөгийн төлбөр тооцоо гүйцэтгэсэн зөрчлийг давтан гаргасантай холбоотой албан шаардлага хүргүүлснийг бүрэн биелүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

<i>/мянган төгрөгөөр/</i>		
Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт	Биелэлт

	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	1,345.6	1	1,345.6	100.0
Албан шаардлага	1	11,859.2	1	11,859.2	100.0
Нийт дүн	2	13,204.8	2	13,204.8	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараах асуудлыг дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

1. БШУЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Л.Цэдэвсүрэн нь 2023 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 2/3151 дүгээр албан бичгээр тус яамны харьяа төсвийн шууд захирагч нарт “2022 оны санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, “ Итгэл үзүүлсэн”, “Түүвэрт хамрагдсан” гэж дүгнэгдсэн байгууллагуудын төсөв, санхүүгийн ажилтан нарт батлагдсан төсөвтөө багтаан балансын урамшууллыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 23.2 дахь хэсгийг үндэслэн олгож болно” гэж хууль, эрхийн актад заагдаагүй **балансын урамшуулал** гэгчийг олгохыг зөвшөөрсөн байна.

Албан хаагчдын ажлын үр дүнг улирал бүр дүгнэж, үндсэн цалингийн 45.0 хүртэл хувиар тооцон үр дүнгийн мөнгөн урамшууллыг олгосон атал 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Зөрчилгүй” дүгнүүлсэн гэх үндэслэлээр тус бүр нэг сарын үндсэн цалинтай тэнцэх буюу нийт 1,982.0 мянган төгрөгийн урамшууллыг давхардуулан олгосон байна.Үүнд:

- Нягтлан бодогч Х.Алтанхүүд 1,114.0 мянган төгрөг,
- Нярав Д.Чулуунд 868.0 мянган төгрөг .

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно.”, 15.1.3: “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” гэсэн заалтыг зөрчсөн байна.

2. Дээд шатны төсөв захирагчаас төсвийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна. Иймд төсвийг бодит гүйцэтгэлтэй нь уялдуулан зардлын бүлэг, зүйл бүрээр төлөвлөж, зарцуулан гүйцэтгэж байх шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 1,974.6 мянган төгрөгийн дараах алдааг залрууллаа.Үүнд:

- Биет бус хөрөнгийн элэгдлийн зардлыг 1,386.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан байна.
- Бараа материалын тайланд 391.0 мянган төгрөгийн үнэ төлбөргүй хүлээн авсан хангамжийн материалыг дутуу бүртгэсэн байна.

- Ажил олгогчоос төлөх 197.6 мянган төгрөгийн НДШ-ийн зардлыг дутуу тайлагнасан байна.

Аудитаар нийт 7,977.5 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 977.8 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 6,999.7 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

5.1 Төлбөрийн акт

1. Номын санч М.Туяад ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдлийг архив бичиг хэргийн цалингаас бус номын санчийн цалингаас тооцож 679.5 мянган төгрөг илүү олгосон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно*”, 20.2.5 дахь “*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү тооцож олгосон нэмэгдэл цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

2. Холбогдох албан тушаалтны тушаал, шийдвэргүйгээр сургалтын менежер Л.Өлзийцэнгэлд 298.3 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдлийг илүү тооцож олгосон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно*”, 20.2.5 дахь “*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон ур чадварын нэмэгдлийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

5.2 Албан шаардлага

1. Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас 152.4 мянган төгрөгийн НДШ-ийн авлага, 6,847.3 мянган төгрөгийн тогтмол зардлын өр төлбөр үүсгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “*Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “*Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*” гэсэн заалтыг байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх албан шаардлага хүргүүлэх.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа	Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан	Буруу тусган илэрхийлсэн	Үүнээс		Зөвлөмж
				Залруулсан	Залруулаагүй	

	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бараа материалын тайланд орлого дутуу тайлагнасан.	1	391.0	1	391.0			1	391.0				
Элэгдлийн зардлыг дутуу тайлагнасан.	1	1,386.0	1	1,386.0			1	1,386.0				
Ажил олгогчоос төлөх НДШ-ийг дутуу тайлагнасан.	1	197.6	1	197.6			1	197.6				
Дүн	3	1,974.6	3	1,974.6			3	1,974.6				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цалингийн нэмэгдлийг илүү тооцож олгосон.	1	977.8	1	977.8								
НДШ-ийн авлага үүсгэсэн.	1	152.4			1	152.4						
Тогтмол зардлын өр төлбөр үүсгэсэн.	1	6,847.3			1	6,847.3						
Дүн	3	7,977.5	1	977.8	2	6,999.7						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Өмнөх зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс 2 мэдээллийг хугацаа хоцроож, 7 мэдээллийг мэдээлээгүй зөрчлийг давтан гаргасан.	1	-			1	-		
Нийт	1	-	-	-	1	-	-	-